



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар A/39

Өвт

└ Хуш модны самар бэлтгэлийг зогсоох тухай ┓

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2014 оны "Журам батлах тухай" А-166 дугаар, 2020 оны "Ойгоос хуш модны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай" А/577 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-өлзий сумын ойн сангийн талбайгаас үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар бэлтгэх хэмжээ дууссан, ой хээрийн түймэр гарах эрсдэл нэмэгдэж буйтай холбогдуулан ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар бэлтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн ойн санд нэвтрэхийг хориглосугай.

2. Ойн сангийн талбайгаас Хуш модны самар бэлтгэх, худалдан авах, тээвэрлэх үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон бүрэн зогсоосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга (цагдаагийн ахмад Д.Энх-Амгалан), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Янжиндулам) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН